



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/79

Алтай хот

Салбар зөвлөл шинэчлэн байгуулах
 тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.7.12 дахь заалт, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, монгол хэлний хэм хэмжээг мөрдүүлэх чиг үүрэг бүхий Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

- | | | |
|-----------------------|----------------|--|
| Зөвлөлийн дарга: | Г.Чинбат | -(Аймгийн Засаг даргын орлогч) |
| Зөвлөх: | С.Цагаанбаатар | -(Соёл, урлагийн газрын дарга) |
| Гишүүд: | | -(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга) |
| | | -(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга) |
| | | -(Есөнбулаг сумын Засаг дарга) |
| | | -(Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга) |
| | | -(Насан туршийн боловсролын төвийн дарга) |
| | | -(Монгол хэл, бичгийн зөвлөх багш 1) |
| | | -(Монгол хэл бичгийн тэргүүлэх багш 1) |
| | | -(Соёл, урлагийн газрын соёлын боловсрол хариуцсан мэргэжилтэн) |
| | | -(“Алтайн мэдээ” сонины эрхлэгч) |
| Нарийн бичгийн дарга: | Ж.Дэлгэрмаа | -(Боловсрол, шинжлэх ухааны газрын монгол хэл, бичиг, уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтэн) |


2. 2022 оны ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг салбар зөвлөл (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/21 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHRN-3A-4 doc



0201000088